

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

үйлчилгээний товч мэдээлэл

12018 оны 12 сарын өссөн дүн

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	106439	102717	64504	42693	2919	319272
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	46841	41482	17752	4701	2496	113272
3	Идэвхтэй хяналтын үзлэг	9541	17429	17573	2308	4	46855
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	34268	17431	7135	5144	399	64377
5	Нийт төрөлт	1243	293				1536
6	Хэвтэн эмчлүүлэгчид	7441	5123		2489	15	15068
7	Нас баралт	43	179	101			323

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 319272 хүнд үзлэг шинжилгээ хийсний 50.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 15068 хүнийг 98399 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 12 сарын өссөнөөр 64377 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7777 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 12 сарын байдлаар 1482 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 50 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 295-р өсч, осол гэмтлийн нас баралт 4-р буурсан байна. Осол гэмтлээр нас барагсдын 26% нь зам тээврийн ослоор, 22% нь амиа хорлож, 10% нь бусдад хорлогдож, 42% нь ахуйн ослоор тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсдын 92% нь эрэгтэй, 12% нь 0-15 хүртэлх насны хүүхэд, 88% нь 16-66 насны хүн эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 74% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан хүмүүсийн 92.3% нь хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна.
5. Оны гарсаар 323 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 15,4% нь осол гэмтлээр, 17% хорт хавдраар, 13.6% зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 5,5% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
6. Нялхсын эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 2 тохиолдлоор өссөн ба 1000 амьд төрөлтөд 14.8 байна.

7. Түргэн тусламжийн 11436 дуудлагад явж үйлчилсний 1607/14%/ нь алсын дуудлага, 489/4.2%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 81.8% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна.
8. Сард дунджаар 3879 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 60.4% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 8 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1%-г эзэлж байна.
9. Нийт 1536 эх төрж 1552 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 761 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1:1,002 байгаа ба эмэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 6,3% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна.
10. Эхний 12 сарын байдлаар 815 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 525,1 байгаа нь өнгөрсөн оноос 57,3% нэмэгдсэн нь анхаарал татаж буй үзүүлэлт байна.
11. Он гараад 634 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 50 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 37,5%-г салхинцэцэг, 1,5%-г Гепатит В С, 10,4%-г гар хөл амны өвчин, 32.4%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. ЭЭСангуудад нийт 20603 жор ирсний 47.6%/9814/ нь ЭМДаатгалын, 0,3% /64/ мансууруулах эмийн, 2% /425/ сэтгэц нөлөөт эмийн, 49,9% /10300/ нь энгийн эмийн жор байсан ба 0,4% /95/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 73,6% байна.
13. БОЭТөвд 43 эндэгдэл тохиолдож 12 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 72% тай байна. Үндсэн оношийн зөрөө 0,5%.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн байдал

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзлэгт 7111, чихрийн шижин илрүүлэх үзлэгт 7473, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 1650, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 9871, элэгний эрт илрүүлэгт 12928 хамрагдаж үзлэг 58% тай хийгдсэн байна. Энд сумдаас Ханбогд,Цогтцэций зэрэг сумдууд Энхийн хүслэн өрхийн эмнэлэг харьцангуй бага хувьтай /50 доош хувьтай/ хамрагдаж байгаад анхаарч эрт илрүүлгийн үзлэгээ идэвхтэй зохион байгуулах шаардлага байна. Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдээс артерийн даралт ихтэй 70 хүн шинээр оношлогдож хяналтад нэмж орсон байна. Эдгээр шинээр хяналтад орсон иргэд стандарт удирдамжийнхаа дагуу хяналтдаа тогтмол хамрагдах шаардлага байна.